



ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2021 оны 12 сарын 03 өдөр

Дугаар А/143

Мөрөн сум

Хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдийн
орны дээд хязгаарт нэмэлт өөрчлөлт
оруулах тухай

Эрүүл мэндийн тухай хуулийн 12 дугаар 12.1.3, Эрүүл мэндийн сайдын 2019 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн А/479 дүгээр тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Эрүүл мэндийн газрын даргын "Төр, хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагын эмнэлгийн тусламж үйлчилгээнд ашиглах орны дээд хязгаарыг батлах тухай" 2019 оны 12 дугаар сарын 11-ны өдрийн А/97 дугаар тушаалын 2 дугаар хавсралтад өөрчлөлт оруулсугай.

2. Ковид-19 халдварын улмаас Аймгийн Нэгдсэн эмнэлгийн орны ачаалал нэмэгдсэн, тасгуудад халдварын өвчлөл бүртгэгдэж түр хугацаанд үйл ажиллагааг зогсоосонтой холбоотойгоор хувийн хэвшлийн ортой эмнэлгүүдэд орны ачааллыг хуваалцаж ажиллах, орны дээд хязгаарт багтаан үйл ажиллагаа явуулахыг хувийн ортой эмнэлгийн дарга нарт зөвшөөрсүгэй.

3. Аймгийн хэмжээнд төр хувийн хэвшлийн түншлэлийг хөгжүүлэх бодлогын хүрээнд хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад орны ашиглалтын байдалд үнэлэлт дүгнэлт хийж ажиллахыг Эрүүл мэндийн мэдээ, мэдээлэл хариуцсан мэргэжилтэн (П.Баярмаа)-д үүрэг болгосугай.

4. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хуулийн зөвлөх (Х.Баттогтох)-д даалгасугай.

ДАРГА



М.ҮҮРИЙНБАЯР

Эрүүл мэндийн газрын даргын 2021 оны
 12 дүгээр сарын 15-ны өдрийн А.1/13 дугаар
 тушаалын хавсралт



ХӨВСГӨЛ АЙМГИЙН ТӨВИЙН ХЭМЖЭЭНД 2020-2021 ОНД
 АШИГЛАГДАХ ЭМНЭЛГИЙН ОРНЫ ДЭЭД ХЯЗГААР

№	Эмнэлгийн эрүүл мэндийн байгууллагын нэрс	Хэвтүүлэн эмчлэх тусламж, үйлчилгээний ор										Нийт орны дээд хязгаар	Өдрийн эмчилгээний ор	Эхчүүдийн амрах байрны орны тоо	
		Эмнэлзүйн эрт үеийн эмнэлгийн цогц тусламж, үйлчилгээний ор	Үүнээс			Өвчний удаан явц, архаг үеийн дагнасан тусламж, үйлчилгээний ор	Үүнээс								Сэтгэцийн ор
			Өвчний хурц /цочмог/ үеийн ор	Өвчний хурцавтар /цочмогдуу/ үеийн ор	Сүрьеэгийн ор		Уламжлалтын ор	Сувилахуйн ор	Хөнгөвчлөх асаргаа сувилгааны ор	Сэргээн засахын ор	Сувиллын ор				
1	Хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллага	Гуамерен	16	10	6	0							16		
2		Жаргалан	24	20	4	0							24		
3		Мөнхтулгуур	30	22	8	0							30		
4		Олондтуслах	10	7	3	10	10						20		
5		Ончинжалба	0			15	15						15		
6		Отоснамнан	20	12	8	0							20		
7		Оюу-Ундраа	34	24	10	0							34		
8		Ренчинжугнай	28	23	5	0							28		
9		Хүмүүн	20	14	6	0							20		
10		Цээнэ	19	13	6	13	9	4					32		
11		Циркон	8	8		0							8		
12		Энх-Үрс	20	12	8	10					10		30		
Нийт дүн		229	165	64	0	48	34	0	4	0	10	0	277	0	0